

Хоёр ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал

Ш. Чоймаа (МУИС)

Хос ёсны сургаал хэмээх нь хэн бүхний мэдэхээр бол ертөнцийн ёс (རྒྱଣ རྩେ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ), номын ёс (རྒྱଣ རྩେ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ རྩ୍ବ) хоёрыг шүтэн барилдуулж, авах гээхийн ухаанаар тунгааж, улс гүрнийг залан засах төрийн бодлого, түмэн олны аж төрөх хэв заншилдаа баримтлах гол зарчмыг ухааруулсан номлолын цогц юм.

Бурханы шашны сургаал ёсоор юуг ертөнц хэмээдэг буй, түүний үүсэл гарлыг юу хэмээдэг буй гэх зэргийг холбон өгүүлбээс, хос ёсны сургаалын үүсэл гарал тодрох болно.

Бурханы шашны сургаалаар, “Эвдрэхийн номт сав хийгээд шим зүрхэн болох шутэгч бодгальс хоёрыг ертөнц хэмээнэ. Газар дэлхий, ус далай нь амьтан нугуудын орогох савын ертөнц хэмээдэг бөгөөд түүнд шутэгч гурван орны (амармагийн¹ орон ዓଡ଼ନ୍ମା, дүрстийн орон ପ୍ରତିଷ୍ଠାନମା, дүрсгүйн орон ପ୍ରତିଷ୍ଠାନମା) амьтан нугууд нь дотоод шим зүрхэн мэт мон тул шимиин ертонц хэлиээгдэх ажээ.”² Сав шим ертөнцийн үүслийн тухай тайлбар домгийг монголын түүхэн сурвалж бичгүүдэд түгээмэл тэмдэглэж, монголын уг язгуур гарвалыг хүн төрөлхтний эртний үүдвэртэй холбосон байдаг юм. Энд XVII зууны монголын түүхэн сурвалж болох Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д хэрхэн өгүүлснийг сийрүүльье.

“Эдүгээ ерөнхийн шутээн гадаад сав ертөнц тогтсон, ерд (хамаг нийт, Ш.Ч.) шутэгч дотоод үр амьтан бүтсэн хоёроос эн тэргүүн гадаад сав тогтсон нь хэмээвээс, гурван зүйл мандалаар тогтвой. Түүнд гурван мандал нь, Зохиогч хийн мандал, Долгилогч усны мандал, Шүтүүлэгч шороон мандал лугаа гурванаас урьд хийн мандал нь, эн урьд хоосны агаарт арван зүгээс их хий хөдлөн янагш чанагш тулалцсанаас, Зөөлөн нэрт хөхөмдөг өнгөт хэнээ бээр үл

¹ Амармаг хэмээх нь одоогийн амраг хэмээхтэй язгуур нэг. Эртний алтай хэл, тухайлбал эртний түрэг хэлэнд “амранмаг” хэмээвээс хүсэл дурлал гэсэн утгатай. Эрт цагт Согд, Уйгураар дамжин бурхны шашин дэлгэрч байх үед “амармагийн орон” хэмээн нэрлэж заншжээ. Хожмын зарим орчуулгад “хүсэлт орон” хэмээх ч буй.

² Dungkar Tibetanological Great Dictionary, (Tibetan language) Beijing, 2002, pp.890.

борчигдохуй (ул эвдрэхүй Ш.Ч.) нэгэн хийн мандал болон тогтвой. Нөгөө усны мандал нь, тэр урьдах хийн дулаанаас Эрдэнийн цогц хэмээх их үүл цогцолж, түүнээс их хур үргэлжид орсноос Хужирт далай нэрт хязгаалал үгүй их далай болон усны мандал тогтвой. Гутгаар шороон мандал нь, тэр усны дээр Алтан зүрхэт хэмээх барамнасын тоосон, сүүнд өрөм байсан мэт тогтох, түүнээс зэргээр долоо долоон хувь болон нарийн тоосон, төмрийн, усны, далайн, хонины, үхрийн үсэн дэх ба нарны туян дахь, хуурс, бөөс, арвайн төдий ба долоон арвай нэгэн ямх, хорин дөрвөн ямх нэгэн тохой, дөрвөн тохой нэгэн алд, таван зуун алд нэгэн лавайн дуун сондохуй (гөрийн, krosa, Ш.Ч.), найман лавайн дуун нэгэн бээр (yojana Ш.Ч.), тэр мэт олон бээрийн чинээт ахуй зузаан Их эрхэт алтан дэлхий нэрт шороон мандал, дунд нь уулсын хаан жавхлант Сүмбэр таг (ул Ш.Ч.), долоон Алтан уулс, долоон Анабадын нуур (эс бүлээдсэн далай, Ш.Ч.), дөрвөн их тив, найман өчүүхэн тив лүгээ арван хоёр тивүүд нэгэн цагт тогтвой.

Нөгөө дотоод үр бүтсэн нь хэмээвээс, нэгдүгээр дияаны нэгэн тэнгэр буурч хүний оронд төрснөөс улам үржээд, Өнгөт ертөнцийн арван долоон орон, Өнгөгүй ертөнцийн дөрвөн орон, Амармаг ертөнцийн хорин орон дахь, ер гурван ертөнцийн зургаан зүйл амьтан зэргээр бүтвэй. Ялангуяа тэдгээр амьтнаас дөрвөн тивийн хүн амьтан хэмээвээс, ерд тэнгэрийн хувилгаан бүхийгээр, насан нь тоо томшгүй насалмуй. Оршируун (оршихдоо Ш.Ч.) дэлхийд шүтэж суун, явруун (явахдаа Ш.Ч.) хөлөөөр хөсрөө (газарт Ш.Ч.) үл яван огторгүйгаар халин явж, идрүүн (идэхдээ Ш.Ч.) [g. идэр] хөсөр дэх буртаг идээг үл идэн, самадийн ариун идээг идэж, төррүүн (төрөхдөө Ш.Ч.) эр эм үгүйеэ умайгаас үл төрөн, хувилгаанаар төрж, үзрүүн (үзэхдээ Ш.Ч.) наран саран үгүйеэ өөрийн биеийн [a.гэгээн] гэрлээр үзэн амуй. Тэр цагт хүн хэмээх нэр үгүй, ерөнхийн (нийтийн Ш.Ч.) нэр нь амьтан хэмэн нэрийдьюү. Хойно нэгэн цагт амтнаа хурьцагч нэгэн амьтан газрын тос хэмээх идээг олж идэн бүхнээр түүнчлэн идсэнээр, урьд самадийн идээ нь устаж, тэр газрын тосыг идэн, огторгуйн явдал нь устаж, хөсөрт (газарт Ш.Ч.) унан, бие дэх гэрэл нь устаж, харанхуй болон сөнирснөөр (сөнөжс устсанаар Ш.Ч.) муухаг нисваанисын тэргүүн тэндээс өдвэй (өдөгдөн үүсвэй Ш.Ч.). Тэндээс ерөнхий (нийт, түгээмэл Ш.Ч.) амьтны үйлийн ач үрээр наран, саран, одон ургаж тэдгээрийн гэрлээр гийгүүлэх болбой. Түүний хойно бас [g. нэгэн] цагт, жич амтанд хурьцагч нэгэн амьтан Ногооны ой хэмээх идээг слж идсэнд, бүхнээр түүнчлэнхүү идэж, насад хөсрийн буртаг идээг идсэнээр эр ба эмийн бэлгэс тэнд гарсанд, нэг нэгэндээ тачааж бүрүүн, хөвгүүн охин төрүүлснээр тачаангуй нисваанисын тэргүүн тэндээс өдвэй. Түүний хойно бас нэгэн цагт, жич амтанд хурьцагч нэгэн амьтан өөсөөн (өөрөө, аяндаа Ш.Ч.) ургасан салу нэрт тутаргыг олж, энэ ямар идээ буюу. Юун л бөгөөс амсаж үзсүгэй хэмээгээд, тэр салу нэрт тутаргыг идэн бүхнээр түүнчлэн идсэнээр урьдах тэр идээ нь жич үгүй болдруун (бологдоход Ш.Ч.), тэрхүү тутаргыг идэх болбой. Тэнд тэрхүү тутаргыг хэзээ идэхүйдээ авч идэн атал, нэгэн залхай амьтан манагарын (маргаашийн Ш.Ч) идэхүйг энэ өдрөө (өдөрт Ш.Ч.) авч тавьснаар урьдах тэр тутарга нь жич үгүй болсноор, найдангуй (атаа Ш.Ч.) нисваанисын тэргүүн нь тэндээс өдвэй (үүдэв Ш.Ч.). Төдий тэр тутаргыг тарьж идэхуй болсонд, тэр мэт доод ертөнцийн

буртаг идээг насад идээд, их идэгсэдийн өнгө муу болон, бага идэгсэдийн өнгө сайхан болсноор миний өнгө сайн, чиний өнгө муу хэмээн нэг нэгнээ доромжлон, бас бээр тэр тутрагыг тарих газадыг (*газруудыг Ш.Ч.*) булаалдан, их хэрүүр (*хэрүүл Ш.Ч.*) өдөж, нэг нэгнээ алснаар урин (*уурын Ш.Ч.*) нисваанисын тэргүүн тэндээс өдвэй. Жич, бас тэр тутрагыг их авагсад нь өчүүхэн авагсадаасаа нууж идсэнээр харам нисваанисын тэргүүн тэндээс өдвэй. Тэндээс [*a.bas*] нэгэн гоо үзэсгэлэнтэй, төв шулуун сэтгэлтэй, гэгээн ухаантай амьтан ирж, урьдах авагсадын зөвтийг нь хайллан, буруутыг нь гэсгээж, хойшид тарихуй газадыг (*газруудыг Ш.Ч.*) нь сацууяа хуваан хамгийг тэгшид асарснаар, тэнд бүхүүн (*байгсад Ш.Ч.*) хотлоор чиний зарлигаас бүү давъя, чамайг ноён өргөө хэмээн ам авалцаж хотлоор ноён өргөснөөр энэтхэгийн хэлээр Маха Самбади ранза, төвдийн хэлээр Манбой гүрбий жалбо, монголчилбоос Олноо өргөгдсөн хаан хэмээжээ. Тэр мэт Самандабадра бурханы шашнаа дөрвөн тивд Алтан хүрд эргүүлэгч Чакраварди хаан хэмээн алдаршжээ. Тэр цагийн нэр нь эн тэргүүн галавуудын урьд Төгөлдрөө туулсан цаг хэмээюу” гэжээ.

Сав шим ертөнцийн дотоод зүй тогтол буюу бүтээгч хүч нь үйлийн үр тул ертөнцийн үйл хүний сэтгэлээс шалтгаалдаг болохыг энэ домогт тодорхой өгүүлжээ. Ялангуяа миний тухайлан өгүүлэх хэмээсэн хос ёсны сургаалын уг үүсвэр ч эндээс тодрох учиртай. Хурьцах сэтгэлээс болж мунхагийн нисваанис, тачаангуйн нисваанис, найдангуйн нисваанис буй болж, улмаар уурын нисваанис, хармын нисваанис зэргээр үүсчээ. Тийнхүү нисваанист үйл арвидаж, хүн хэмээх амьтан өөрсдөө зөв буруугаа олж, эв эеэр амьдарч чадахгүйд хүрэх үес “зөвтнийг нь хайллан, буруутныг нь гэсгээх” хүн төрөлхтний анхны хаан гарч иржээ. Олонхоороо зөвшиж, бүгд чиний зарлиг зааврыг дагая хэмээсэн тул “Олноо өргөгдсөн хаан” (МОНГОЛЫН НАДАРШААН) хэмээн алдаршжээ.

Хожмын түүхэн сурвалж бичиг тэргүүтэнд номт сайн хааныг түүнтэй жишин адилтгаж бичдэг тогтсон уламжлал буй болжээ. Төрийг төвшин барьж, зөв буруу, буян нүглийг алдаагүй ялгаж, нийгэм олныг үл алагчлагч номт сайн хааны хэв дүр болон дурдагдаж, улмаар хүмүүн төрөлхтний анхны хаан тийм байсан юм хэмээн сануулж, хожмын хаад түүнтэй адилтган өөрийн биеэ үгүйлэхийг ч давхар бодуулахыг хичээн түүх намтарт тийн өгүүлдэг байжээ.

Өмнө өгүүлсэн сав ертөнцийн үүслийн тайлбар домогт “номын ёс”-ны үүсэх болсон шалтгааныг ч мөн үзүүлжээ хэмээн хэлж болно. Хаан төрийн хатуу цааз хуульд өртөх гэм буруугийн шалтгаан нь нисваанист сэтгэлийн гэм алдал юм хэмээхийг илэрхий заан өгүүлсэн тул тэрхүү сэтгэлийн гэмийг л тэвчвэл зөв мөрд орох нь тодорхой буй.

Тийн аваас, нисваанист сэтгэлээр гэм бурууг үйлдэж, хааны цаазаар гэсгээгдэхээс өмнө сэтгэлээ ариусгаж, бие, хэл, сэтгэлээ засах нь үл осолдох нийтлэг хэв ёс болохыг ухуулан таниулж, шалтгааныг мэдүүлж, өөрөө өөрийн сэтгэлийг шинжлэн, номхтгох л эрхэм болохыг зааж өгөх хэрэгтэй ажээ. Энэ нь номын ёс, Бурханы сургаалд нийцэж очно. Буянт буюу нүгэлт үйл алин болохыг авах гээхийн ухаанаар төгс ухаж, ертөнцийн явдлыг удирдах хаан бол номт хаан бөгөөд тийм хааны,

төр улсаа засан төвхнүүлэх засаг нь ч хос ёс болох юм. Хаан хүн ертөнцийн аливаа үйлсийн магад учрыг хянаж, сайн мууг ялгаж, албат иргэнийхээ жаргал зовлонг ухаарах хэмээвээс зайлшгүй үйлийн үрийг танин барих хэрэгтэй. Энэ нь хос ёсоор, төрөө засдаг хааны гол шинжийн нэг бөгөөд нүглийг тэвчиж, буяныг арвитгахын уг язгуур нь тодрох билээ.

Бурхан багш бээр

*“Нүгэл алиныг ч бүү үйлд.
Буяны хотол чуулганыг эдэл.
Өөрийн сэтгэлийг огоот номхтго.
Энэ нь бурханы шашин мөн”*

хэмээн айлдсан. Энэ сургаал нь хос ёсоор төрийг засах хаан хүний насад дагах мөр нь болж, ард олны “биенийг хураах бус сэтгэлийг хураах” эрдэм нь болж өгдөг байжээ.

“Хоёрдугаар Бурхан багш” хэмээн өргөмжлөгдөн алдаршсан “Энэтхэгийн Буддын их сэтгэгч Нагаржунын сургаал Монгол оронд өргөнөө дэлгэрч, монголын ард түмний сэтгэлгээнд нөлөөлсөн бөгөөд ... Нагаржuna Эзэн хаанаас энгийн иргэд хүртэл бүгдэд зөвлөн сургаал айлддаг номын их багш байжээ. Түүний зохиосон төр суртахууны шастир буюу сургаалын зохиолоос, хаанд зориулсан “Эрдэнийн эрих”, “Хаанд илгээсэн захидал”, түшмэлд зориулсан “Билгийн гол модон”, харц албатад зориулсан “Рашааны дусал” зэрэг нь ихэд түгэж³, төвд, монгол оронд хос ёсны сургаалын зохиол олноор туурvigдахын эх ундарга нь болсон билээ. Нагаржuna бээр “Хаанд илгээсэн захидал”-даа:

*“Гэрлээс гэрэлд
Гэрлээс харанхуйд
Харанхуйгаас харанхуйд
Харанхуйгаас гэрэлд одох мэт
Хамаг дөрвөөс анхныхыг нь зохиогтуун.
Дотроо болсон, гаднаа түүхий
Дотроо түүхий, гаднаа болсон
Дотор гадна хоёулаа түүхий
Дотор гадна хоёулаа болсон анаар жимс шиг
Дөрвөн зүйл хүн буйг онож зохиогтуун.”⁴*

хэмээн айлджээ. Эш татсан сургаалаас үзэхэд, улс гүрний төр барьсан хаан хүн болбоос, “гэрлээс гэрэлд” одох мэт үйлстэй, дэргэдийн шадар түшмэдээс харц албат хүртэлх иргэн олны “болсон (оловсурсон), түүхий” хоёрыг онож ялгадаг байх нь номт хааны явдал болохыг айлджээ.

³ Нагаржuna, Дундад үзлийн чуулган, Эрхэлсэн Г. Лувсанцэрэн, УБ, 2002, VII тал.

⁴ Хутагт Нагаржuna, Хаанд илгээсэн захидал, орчуулсан, тайлбарласан А. Батцэнгэл, УБ, 2007, 19-р тал.

Эд бүгдийг товч дүгнэж өгүүлэхэд, судар шастирт алдар нь мөнхөрсөн номт сайн хаад нь шашин, төр хоёрын зөв мөр, зөв номлолыг өөрийн биедээ хосолж чадсанаар алдаршдаг ажээ.

Монголын түүхэн сурвалжуудад ертөнцийн анхны хааныг “Олноо өргөгдсөн хаан” (Mahāsammati, Mahaśamadati) хэмээн бичиж, түүний тавдугаар үеийн “Хүрдэн эргүүлэгч” (Хүрдэн орчуулагч, cakravartin, चक्रवर्ती) хааны тухай олонтаа өгүүлж, мөн хожмын монголын хаадыг ч адилтгах буюу бас тийм цол өгөх ч зүйл байсан билээ.

Хүрдэн орчуулагч хааны тухай Эртний Энэтхэгийн алдарт бандида, ертөнцийн зургаан чимгийн нэгэн хэмээн алдаршсан Васубандхугийн зохиол “Илт номын сан”-гийн гуравдугаар бүлэгт эдгээр хаадын тухай ийн өгүүлжээ.

«Ертөнцийн хүмүүс түм орчим насладаг байх үес, эртний Энэтхэгийн анхны хааныг “Олноо өргөгдсөн хаан” хэмээн нэрийдсэн ажээ. Түүнээс зэрэг дараалан Үзэсгэлэнт Гэрэлт хаан тэргүүтнээс тавдугаар хаан нь Тэтгэн Асрагч Хутагт (Тэтгэн Асрагч) хаан бөгөөд түүний толгойн оройн махан ур бацуугаас гарсан нь “Намайг хөх хаан”, түүний баруун гуяны ур бацуугаас гарсан нь Үзэсгэлэнт хаан, зүүн гуяны ур бацуугаас нь Шадар Үзэсгэлэнт хаан, баруун хөлний ур бацуугаас нь Төгс Үзэсгэлэнт хаан, зүүн хөлний ур бацуугаас нь Шадар Төгс Үзэсгэлэнт хаан гарсан болой. Энэ тавыг “Хүрдэн эргүүлэгч таван хаан” хэмээх энэ мөн» гэж бичжээ.”⁵

Харин “Хураангуй алтан товч” зэрэг монгол түүхэн сурвалжууд тэдгээр тавыг эцэг хөвгүүд байсан хэмээн бичдэг болой. Эртний Энэтхэгт тэргийн хүрд мэт эргэлдэх хүч уvdис ихтэй чакра хэмээх зэвсгийг эзэмшиж, ертөнцийн олныг эрхэндээ хурааж, хатуу застаар нүгэлт үйлийг тэвчүүлэгч хаадыг “Хүрдэн эргүүлэгч (Хүрдэн орчуулагч) хаан” хэмээдэг байжээ. Бурхан багшийн шашинд номын уvdис түгээж, ном номлохыг мөн номын хүрд эргүүлэх хэмээдэг нь тэрхүү эртний уламжлалт үг ухагдахууныг авсан хэрэг болов уу.

XVII зууны эхэн үеэс тун олноор зохиогдох болсон монголын түүхэн сурвалж бичгүүдэд, монголын хаадын удмыг “Олноо өргөгдсөн хаан”, “Хүрдэн эргүүлэгч хаан” зэрэгээс шууд уламжилсныг заан бичих болсон. Үүнийг манай зарим судлаачдын бичдэгчлэн, Бурханы шашны нөлөө түүх бичлэгт шууд нөлөөлсөн хэмээн үзэх нь тун учир дутмаг хэрэг.

Бид XVII зууны үед Монголчуудад ямар аюул нүүрлэж байсныг сайн мэднэ. Түүх бичлэгийн энэ чиг нь уг удмаа үл мартуулах, урьд хождын монгол хаадын үйлдсэн үйлийг ертөнцийн хүрээ цараанд өргөн сайшаах нь тухайн цаг үе хийгээд хожим хойч үед олон талын тус хэрэгтэй байсныг монголын бичгийн мэргэд нэвтэрхий ухаарсан зүйл юм. Монголын хаадыг ертөнцийн анхны хаан Махасамади-гаас уг гарвалтай болгосон нь монголчууд чинь нэн эртний хүн зон юм шүү, эрт язгуурын хаад маань тийм буянтан байсан юм шүү гэдгийг товч тодорхой зарлан тунхагласан хэрэг

⁵ Хаадын үндсэн хураангуй алтан товч, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, V боть, монгол бичгээс хөрвүүлж тайлбарласан Ш. Чоймаа, Улаанбаатар, 2006, 31-р тал.

байлаа. Тэгвэл тэр эртний Махасамади хаанаас эхэлж, төрийг төвхнүүлж, засгийг засаж байсан сайн хаан бүхэн нь хос ёсыг мөрдөж байсан гэдэг санааг ил болон битүүгээр бичиж иржээ. Энэ нь Күнзийн суртал мэтэд том хаалт болж, өөрийн уг язгуураараа бахархах сэтгэлтийг төлөвшүүлж, монголоо хэмээх чин сэтгэлийг цээжинд нь хадааж, үндэсний бичиг соёл, шашин шүтлэгээ дээдэлдэг монгол хүнийг буй болгодог байжээ.

Монгол хаад, төрөө засахдаа хос ёсыг анхааран авсан цаг үе нь өнөөгийн судлаачдын баримт нуталгаагаар бол их эзэн Чингис хааны үед холбогдох ажээ. Их эзэн Чингис хааны үйлдсэн агуу их үйлийг Сүн далайгаар угааж, Сүмбэр уулаар даравч тус нэмрийг эс олж, цаг улирч, цас хайлах тутам Их эзний эрдэм билиг, суу авьяас, хэтийг харсан төрийн бодлого зэрэг нь улам тодорч, үгүйсгэж үл чадах гэрч баримттай судалгаа буй болсоор байна.

Сүүл үеийн зарим судалгаанаас дурдвал, Өвөр Монголын түүхч Чойж бээр “Итгэмж бүхий баримт бичгүүдийг сайтар байцааваас Монголчууд Бурханы шашин лугаа анх барилдсан буюу шашны хүндлэл гарсан нь харин ч Чингис хаан бээр 1206 онд “Их Монгол Улс” юугаан үүсгэн байгуулсны хойно Монголчуудын гадагш харь орон лугаа дайлалдах аян дайныг дагалдан, Төвдийн Бурханы шашин ба Хятад орон дахь Бурханы шашин лугаа анхны холбоо авч үүсгэснээс эхлэн Монголд Бурханы шашны хүндлэл гарсан хэмээхийг бид үндсэндээ баталж болмуй”⁶ хэмээжээ.

Монгол улсын нэрт эрдэмтэн Л. Хүрэлбаатар бээр, төвд хэлт сурвалж бичгүүдийг сайтар судалж, Чингис хаан хийгээд Бурханы шашны тухайд дүгнэж бичихдээ,

“Ер нь Бурханы шашнаар дамжсан Төвд, Монголын хаадуудын харилцаа нь арга билгийн гүн ухаан, хатуу зөөлөн үйлсийн харилцан шүтэлцээ, ном төрийн гадаад дотоод холбоо, шашин төрийн “хос ёс”-ны сургаалд гайхамшигтай нарийн зохицож ирсэн үе үеийн түүхийг илтгэнэ. Чухамхүү энэ үүднээс авч үзвэл, энэ мэтээр Чингис хааны “Буруу үзлийн замд оршсон” арван хоёр бага хаадыг номхтгож, Бурханы шашны нэгэн том нэгдлийн дор зохилдох нөхцөлийг бүтээж харшилдах нөхцөлийг арилгахыг зорьсон нь зэвсгийн хүчээр улсын талыг алддаг хаадын явдлаас номын хүчээр ертөнцийн талыг авдаг номт хаадын бодлогын бодит жишээ болно... Чингис хаан бол өнөө бидний хэтийдүүлэн үзэж, мушгин тайлбарлаж байгаа шиг, гагцхүү нутгийг тэлэх, авах идэх, алах хөнөөхөд чиглэсэн хар дайны бодлогоор улс иргэнийг уулгалан сүйтгэхийг нэгэн хэргийн зорилго болгосон бус, бас хар бөө тал хэнгэрэгтний ёсыг туйлд гартал шүтсэн нэгэн ч бус, чингэснээс бас хамаг бүх шашныг шүтэх хэрэгтэй хэмээн зарлигдан тунхагласан нь бүр ч биш, харин төрийг тэтгэх амьтныг жаргаахын тулд, алив зарчим журам, хууль ёсыг дорно дахины эртний их иргэншилт улсын ёсноос авч, сэтгэлийг засах оюуныг гэгээрүүлэхийн тухайд энэтхэгийн судар номын ёсноос сурч, Төвдийн номын мэргэдийг “улсын багш”-д шүтэж ирсэн тэр их уламжлалын алтан аргамжийн бодлогыг хойч үедээ атгуулсан, чухамхүү номт хаан байжээ. Ер нь Чингисийн хураасан улс иргэн

⁶ Чойжи, Монголын Бурханы шашин түүх, (Их Монгол улсын үе, 1206-1271), (монгол бичгээр), Хөх хот, 1998, 119-р тал.

дотор олон шашны хүмүүс байсан нь нэг хэрэг, олон шашинтны улс болгосон нь харин түүхэнд гэрчгүй хэрэг”⁷ хэмээн бичжээ.

Энд профессор Л. Хүрэлбаатарын бичсэнийг задлан өгүүлэх боломжгүй бөгөөд ташрам болгон тэмдэглэхэд, өнөөгийн зарим судлаачдын омтгой үзэл дүгнэлтэд өгөх хариулт тодорхой байгааг болгоноо буй за.

Монголын хаад ноёд Бурханы шашны хос ёсны сургаалаас бодтой суралцаж эхэлсэн нь Өгөөдэй хааны гуравдугаар хүү Годан (1206-1251) ноёны үед хамаарна. Монголын цэрэг 1240 онд Төвдийг дайлах явцад Төвдийн Сажавагийн ёсны IV богд Сажабандида Гунгаажалцаныг урин залсан жуух бичиг нь:

“Мөнх тэнгэрийн хүчинд
Их суу залийн ивээлд
Хааны зарлиг ману.
Сажа Бандида Гунгаажалцан Балсамбууд дуулгахуй бичиг.

Бид бээр эцэг эх ба тэнгэр этүгэний ачийг ачлахын тулд мөрийн авах, гээхийг эндуурэлгүй заан мэдэгч нэгэн лам хэрэгтэй. Ажиглаваас Сабан (Сажа бандида) чи, зохистойд санагдах тул чи бээр зам гудасын бэрхшээлийг цээрлэл үгүйгээр ирэх хэрэгтэй. Хэрвээ чи өтлөв хэмээвээс эрт Шагжамуни олон амьтны тусад биеz тоолшгүй өглөг өгснийг дурдах үгүй юу? Чи бээр дээд номыг сурхай мэдэхүйдээ ам алдсан юугаан эгнэгт зөрчих нь мөн бус? Эдүгээ би бээр хязгаарын засгийг бүгд мэдлээ. Хэрвээ их цэрэг хөдөлгөж, олон амьтанд хорловоос чи огоот үл эмээмүй юу? Иймийн тул чи бээр Бурханы шашин ба олон амьтны тус амгаланг бодож түргэн урагш иртүгэй! Наран шингэх зүгийн олон хуврагийг чиний мэдэлд оруулах зохистой.

Соёрхох эд, цагаан мөнгө таван их өлгий (юмбүү), зургаан мянга хоёр зуун мөхлөг сувдын шигтгээрт гарша дээл, ал шар хэмэрлиг тортон мөрөвч, бойбог, өвч энт цэцэгт дурдан хоёр бүхэл, өвч энт өнгөт торго хоёр бүхэл, таван өнгийн хэмэрлиг торго хорин бүхэл буй. Үүний тулд Дор-сри-гон (Доржшигэн), Бонжодарма (Бонжодарма) хоёрыг томилон хүргэвэй.

Лuu жилийн найман сарын гучны өдрөө бичвэй”⁸ хэмээжээ.

Энэ луу жил бол 1244 он болно. Сажа бандида Гунгаажалцан бээр ач хүү арван настай Пагва, зургаан настай Чагна (Чагнадорж) хоёрыг дагуулан мөн онд мордож, урт замыг туулан, 1246 онд Лянжуу (Одоогийн Ганьсу мужийн У-вэй хот) хотод хүрчээ. Годан ноён Гүег хааныг хаан ширээнд залах ёслолд явсан тул хүлээн суусаар, 1247 онд тэд золголдсон ажээ. Монголын түүхэн сурвалж бичгүүдэд Сажа бандида

⁷ Л. Хүрэлбаатар, *Чингис хаан ба Монголын Бурханы шашин*, Чингис хаан ба Монголын Бурханы шашин сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ, 2006, 15-16-р тал.

⁸ Агаангунгаасоном, “Сажавагийн үе залгамжийн түүх” (Сажавагийн үе залгамжийн түүх) -ээс Чойжийн орчуулсныг төвд эхтэй нь харгуулан засаж авлаа.

Гунгаажалцаныг Лянжуу-д байхдаа шашин, амьтны тусыг сайтар зохиолоо хэмээн нэгэн адил тэмдэглэсэн байдаг.

Сажа бандида Гунгаажалцан бээр Төвд орны Уй, Зан, Ари зэргийн буяны садан, өглөгийн эзэд тэргүүтэнд илгээсэн бичигтээ, “Годан хаан бээр өгүүлэхдээ, “...Хутагтын ач нар бээр урьд төвдийн ном сурсан буй. Эдүгээ ч Пагва бээр төвдийн ном сурагтун. Чагнадорж бээр монгол бичиг (ᠴᠠᠭᠱᠠᠵ) хийгээд монгол хэл (ᠮᠣᠩᠭᠣᠯ) сурагтун. Би ертөнцийн номоор (ᠮᠣᠩᠭᠣᠯ) тэтгэе. Чи дээдсийн номоор (ᠮᠣᠩᠭᠣᠯ) тэтгэвээс Шагжамунийн шашин гадаад далайн чинадаас нааш түгэх бус уу...”⁹ хэмээн дурдсан нь чухамдаа шашин, төрийг хослох тухай өгүүлсэн хэрэг болно. Энэ нь улмаар Юань гүрний үед Хубилай хаан, Пагва лам нарын үйлсээр бүрэн биеллээ олсныг хойно өгүүлнэ.

Сажа бандида Гунгаажалцан бээр Монголчуудад Бурхан багшийн сургаал номлолыг түгээхдээ, эн тэргүүнд хаад ноёдоос харц албат хүртэл ойлгож чадах буюу тэдний саванд таарсан сургаалыг айлдваас нийтийн сэтгэлийг хурааж чадах төдийгүй Бурханы шашны уг үндсийг номлох боломж нөхцөл бүрдэх байсан буй за. Түүний зохиосон “Сайн угт эрдэнийн сан” буюу “Субашид” хэмээх 9 бүлэг, 457 бадаг зохиол нь хос ёсны сургаалаар олон иргэдийг гэгээрүүлэхэд чухамхуу яв цав нийцэж байсан хэмээж болно. Академич Ц. Дамдинсүрэн гуайн бичсэнчлэн, “Субашид”-ыг Сажа бандидыг амьд сэргүүн байхад монгол хэлнээ орчуулж байсан байж болох юм.¹⁰ Лавтай XIII зууны эцсээр тарнич тойн Соном-гара монголоор орчуулж, бас дөрвөлжин үсгээр хоёр ч удаа хэвлэгдэж байсан нь өнөөгийн судалгаагаар тодорхой болжээ. Түүнээс хойш XX зуун хүртэл олонтаа орчуулагдсан байдаг. Хос ёсны сургаал Монголчуудын дунд түгэн дэлгэрэхэд ч, ер нь сургаалын монгол зохиолын хөгжилд ч Сажа бандида Гунгаажалцаны “Субашид” тун их нөлөөлсөн нь магад үнэн билээ.

Хубилай хаан анх 1253 онд Пагва ламыг ордондоо залж, улмаар Хээбазар (阿拔子 He vajra)-ын авшиг авч, багш шавийн барилдлага барьсан түүхтэй. 1260 онд Хубилай бээр Шанду-д Их Монгол улсын хаан ор сууж, мөн оны 12 дугаар сард Пагва лам Лодойжалцан (1235-1280)-ыг “Улсын багш” (guo shi) өргөмжлөв. 1270 онд “Хааны багш” (di shi) хэмээн дэвшиүүлэн өргөмжилсөн ажээ.

Хубилай хаан бээр 1264 онд Төвд орны “Тойд иргэнээ дуулгахуй зарлиг” болох “Мүдигма” (慕義盟 буюу Сувд бичиг) хэмээн алдаршсан жуух бичгийг буулгажээ. Энэхүү зарлиг бичигт,

“Мөнх тэнгэрийн хүчинд
Их суу залийн ивээлд
Хааны зарлиг ману.

⁹ Агваангунгаасодном, “Сажавагийн үе залгамжийн түүх” (蒙古汗朝の歴史), (төвд хэлээр), Бээжин, 1986, 136-р тал. Энэ чухал баримт бичгийг Зава Дамдин бээр “Алтан дэвтэр”-тээ оруулжээ. (Ш. Бира, О Золотой книге) Ш. Дамдина, УБ, 1964, 69-р талд үзнэ үү.)

¹⁰ Эрдэнийн сан Субашид, хэвлэлд бэлдсэн Ц. Дамдинсүрэн, УБ, 1990, 6-р тал.

Тойдод, иргэнээ дуулгахуй нь, энэ өртөнцийн хотол төгсөхүйг Чингис хааны засгийн ёсоор (*Чингис хааны засгийн төвийн*) явбаас болон бөгөөтөл хойтын тусыг номын ёсноо (*Чингис хааны засгийн төвийн*) шүтэх хэрэгтэй хэмээсэн утгыг сайтар шинжилж, Бурхан Шагжамунийн энэ мөр чухам ариун хэмээн мэдээд, тэр мөрийг өөрөө сайтар онон, бусдад бээр буруугүй сайтар үзүүлэгч энэ миний багш Пагва лам мөн тул ...”¹¹ гэх зэргээр бичжээ.

Хубилай хаан бээр хос ёсны бодлогоо энэхүү “Мудигма” зарлигийн эхэнд тодорхой өгүүлжээ. Өөрөөр хэлбэл, төрийг засагч хүн “Чингис хааны засгийн журам” (*Их засаг, Билиг сургаал гэх мэт*)-ыг даган явж болох ба шашкы ёсыг баригч хүн “Бурхан багшийн номын ёс”-ыг дагах хэрэгтэй хэмээн зарлиглажээ.

Юань гүрний үеэс хос ёсны сургаалыг төрийн бодлогод шүтэн барилдуулж, нарийн чанд тогтоосныг “Арван буянт номын цагаан түүх”-ээс үзэж болно. “Цагаан түүх”-ийн үндсэн үзэл нь хос ёсны сургаал бөгөөд “Үнэн хоёр ёсныг тэгшид эндүүрэлгүй явуулахуйн товчоон Арван буянт номын Цагаан түүх”¹² хэмээн нэрлэн тодорхойлсон нь агуулгаа товчилсон мэт юм. “Цагаан түүх”-ийн анхны эхийт ихэнх судлаач Хубилай хааны үед Пагва ламын оролцоотойгоор зохиогдсон гэж үздэг.

Хубилай хаан бээр Юань гүрний төр улсыг засахдаа, нэгэн талаас хааны барьсан иргэнийг захирах төр, нөгөө талаас улсын багш тэргүүлсэн шашин номоор иргэнийг гэгээрүүлэх төр хоёрыг нэгэн сууринд шүтэлцүүлэн тавьжээ. Тэгхээ “хоёр ёсыг холилгүй” өөр өөрийн үйлийг явуулахын хамт харилцан бие биеэ нөхөж чадвал “үнэн номын засаг хивийн зангиа мэт алдаршгүй, хүнд хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй”¹³ байх болно хэмээн үзжээ.

“Үнэн номын засаг” буюу шашин номын сургаал нь хив торго мэт зөөлөн аргаар хүний сэтгэлийг гэгээрүүлэн засаж, нүглийг тэвчүүлж, буяныг үйлдүүлж чаддаг ажээ. Харин “хүнд хааны засаг” буюу “төрийн төмөр нүүр” болсон хууль цааз нь хатуу ширүүн аргаар, алтан буулга хүзүүнд буух мэтээр гэмтэн зэмтэн, буруутан нүгэлтнийг гэсгээж, зөв мөрд хүчээр оруулдаг ажээ. Хос ёсны зөөлөн хатуу буюу дотно гаднаас нөлөөлөх энэ шинжийг “үнэн номын төр дотоод зүрхэн, хүнд хааны төр гадны хар илд мэт буюу”¹⁴ хэмээн “Цагаан түүх”-д зүйрлэн бичжээ.

“Энэхүү хоёр ёсны аль аль нь дутаж болшгүй гэдгийг “Цагаан түүх”-д ”ер хоёр ёсноор эс явбаас буян хилэнц хоёр, цагаан хар хоёр, хүнд хөнгөн хоёр, үнэн худал хоёр, сайн муу хоёр, жаргал зовлон хоёр эд бүхний ялгалыг үл мэдэхийн тул... тэр мэт

¹¹ Агаангунгаасодном, “Сажавагийн үе залгамжийн түүх” (*Чингис хааны засгийн төвийн*), 160-р тал. Мөн “Эзээрэл хүслийг хангагч чандамани” хэмээх зохиолд буй. Орчуулга нь Чин улсын үеийнх.

¹² Арван буянт номын цагаан түүх, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал II, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ш. Чоймаа, Р. Төрдалай, Б. Баатархан, УБ, 2006, 21-р тал.

¹³ Арван буянт номын цагаан түүх, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 2, УБ, 2006, 31-р тал.

¹⁴ Арван буянт номын цагаан түүх, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 2, УБ, 2006, 31-р тал.

номын засаг угүй бөгөөс амьтан тамд унаюу, хааны засаг угүй бөгөөс улс аймаг эвдрэх больюу” хэмээн дүгнэжээ¹⁵.

Юань гүрний үеэс эхлээд ХХ зууны эхэн хүртэлх түүхэн сурвалж бичгүүд, бусад утга зохиолын дурсгалуудад байдаг “хос ёс”-ны сургаалын тухай сонин баримт хэрэглэгдэхүүнийг энд багтаан өгүүлэх боломж үгүй юм.

Академич Ш. Бира гуайн бичсэнчлэн, “1911 онд Монгол тусгаар тогтолцоо тунхаглаж Богд Живзундамбыг хаан ширээнд залахдаа “Шашин төрийг хослон баригч” Богд хаан хэмээн өргөмжилж, оны цолоо “Олноо өргөгдсөн” хэмээх болсон нь хуучны “хоёр ёс”-ны бодлогын шууд үргэлжлэл байсан юм. Ер нь монголчууд үндэсний хаан төрөө бэхжүүлэхийг эрмэлзэх бүртээ “хоёр ёс”-ны бодлогыг баримтлан явуулахыг эрхэмлэж байсныг Монголын түүхээс олж үзэж болно”¹⁶.

Агуулгыг товчлон тодотгохуй

Хос ёсны сургаалыг сав шим ертөнц буй болж, улмаар ертөнцийн анхны хаан хэмээдэг Махасамади буюу “Олноо өргөгдсөн” хаан гарч ирсэн түүхэн домгоос улируулан авч үзэхийг хичээв.

Монголчуудын дунд хос ёсны сургаал дэлгэрсний эх нь Годан (1206-1251) ноён бээр Сажа бандида Гунгаажалцан (1182-1251)-ыг урин залж, Бурханы шашины номлолд сэтгэл өгтөх болсон үе ажээ. Годан ноён бээр Сажа бандида Гунгаажалцанд зарлиг болсон үгэндээ: “Хутагтын ач нар бээр урьд төвдийн ном сурсан буй. Эдүгээ ч Пагва бээр төвдийн ном сургтуун. Чагнадорж бээр монгол бичиг (ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᡱᠴᡳᡤ) ¹⁷ хийгээд монгол хэл (ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯ) сургтуун. Би ертөнцийн номоор (ᠮᠤᠳᠤᠳ) тэтгэе. Чи дээдсийн номоор (ᠮᠤᠳᠤᠳ) тэтгэвээс Шагжамунийн шашин, гадаад далайн чинадаас нааш түгэх бус уу...” хэмээсэн нь, 1629 онд Агваангунгаасодномын зохиосон “Сажавагийн үе залгамжийн түүх” (ᠰᠠᠵᠠວᠤᠭᠴᠶᠢᠨ ቅᠹᠰᠳᠳᠳᠳ) -д эх хэлбэрээрээ уламжилж ирсэн юм. Годан ноёны

¹⁵ Монголын философиийн түүх, (XIII-XVIII зуун), редактор Г. Лхагвасүрэн, Д. Дашжамц, II дэвтэр, УБ, 2000, 264-р тал.

¹⁶ Ш. Бира, Монгол, Японы Буддын шашны ба төр улсын үзэл санаа, уламжлалы харьцуулан судлах асуудалд, Ш. Бира, Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа, III, УБ, 2001, 171-р тал.

¹⁷ Судлаачид 1249 онд бичсэн хэмээн үздэг Сажа бандида Гунгаажалцаны энэ бичигт өгүүлсэн Хор-ег (ᠮᠣᠩᠭᠣᠯ) буюу монгол үсэг нь монгол бичгийг хэлсэн буй. Энэ үед дөрвөлжин бичгийн тухай сураг ч үгүй цаг шүү дээ. Монгол бичиг эрт цагт ямар хэмжээнд дэлгэрч, хэрэгцээ шаардлага нь хэр байсныг гэрчлэх сонин баримт энэ мөн болно. Годан ноён бээр өөрийн дэргэдийн хүмүүст тийм шаардлага тавьсан бол энгийн хэрэг. Харин дөнгөж танилцаж буй төвд хүүхдэд тийм зарлиг буулгасан нь судлууштай зүйл. Ямар боловч монголын ярианы хэл сурах нь хангалтгүй, монгол бичгийг хамтад сурах нь зайлшгүй чухал хэрэгцээтэй байжээ.

өгүүлсэн хүний ном (*Чингисийн ном Ш.Ч*) (ертөнцийн ном Ш.Ч), дээдсийн ном (*Чингисийн ном Ш.Ч*) хэмээх нь хос ёсны сургаалаар явах зохистойг бодтой өгүүлсэн хэрэг билээ.

Юань гүрний үед Хубилай хаан бээр төрийн бодлогодоо хос ёсыг чанд баримтлах болсон тухайд, “Цагаан түүх”-ээс өмнө 1264 онд Төвдийн лам хувраг, нийт олонд дуулгах зарлиг (*Мудигма буюу Чингисийн эхийн түүхийн шүтэх хэрэгтэй хэмээсэн утгыг сайтар шинжилж, Бурхан Шагжамунийн энэ мөр чухам ариун хэмээн мэдээд, ...*”

“Энэ ертөнцийн хотол төгсөхүйг Чингис хааны засгийн ёсоор (Чингисийн түүхийн шүтэх хэрэгтэй хэмээсэн утгыг сайтар шинжилж, Бурхан Шагжамунийн энэ мөр чухам ариун хэмээн мэдээд, ...”

Хамгийн албанитийн өгүүлжээ. Энэ нь хос ёсны сургаалыг бодтой явуулахын учрыг тайлбарласан Хубилай хааны уг билээ.

“Цагаан түүх” нь хос ёсны сургаалаар шашин төрийг тэгшид явуулж, түмэн олны бие, хэл, сэтгэлийг амар амгалан болгоход баримтлах засаг цааз мэт бичиг баримт тул зохих хэмжээнд товч агуулгыг өгүүлэв.

Академич Ш. Бира гуайн бичсэнчлэн монголчууд үндэсний хаан төрөө бэхжүүлэхийг эрмэлзэх бүртээ “хоёр ёс”-ны бодлогыг баримтлан явуулахыг эрхэмлэж байсан юм. Бидний сайн мэдэхээр, Түмэдийн Алтан хаан бээр Содномжамц хутагтыг залж, “Далай лам” цол өргөж, Богд Зонхавын шашныг өргөн дэлгэрүүлсэн билээ. Үүний үүдэл санаа хэрхэн гарсныг Саган сэцэний “Эрдэнийн төвч”-д “Хутагтай сэцэн хунтайж Алтан хаан авгадаа (1576) золгохоор одоод, ... эдүгээ баруун этгээд ахуй Цастны орноо Үзэгч эрхэт их нигүүлсэгч хоншим бодиства бодот биеэрээ буй ажгуу хэмээн. Түүнийг залж эртний богд Хубилай сэцэн хаан, хутагт Пагва лам хоёрын ёсоор шашин төрийг байгуулбаас гайхамшиг бус уу” хэмээн айлтгасанд, Алтан хаан маш зөвшөөн, даруйд Баруун гурван лугаа эдээж, мөн тэр улаан хулгана жилээ (1576 онд) Алтан хааны Адуса дархан, Энх дархан хоёр, Сэцэн хунтайжийн Хонходой даян багш тэргүүтнийг илгээж Богд хамгийг мэдэгч Содномжамц хутагтыг залбай”¹⁸ хэмээж буй.

Энд бас 1674 онд V Далай лам Агаанлуvsанжамц бээр Халхын Түшээт хан (*Чингисийн түүхийн шүтэх хэрэгтэй*)-д тухайлан зориулж бичсэн “Хос ёсны сургаал Улаан сувдын эрих” хэмээх сургаалын зохиолыг дурдах ёстай.

V Далай лам бээр урьдын номт хаад хос ёсоор улс гүрнийг тэгш тэтгэж байсан бол эдүгээ Энэтхэг, Хятад, Төвд, Монголд машид доройтсоныг өгүүлээд, тухайн цаг үеийн монголын хаанд санамж сээрэмж болгон айлдсан сургаал болно.

¹⁸ Саган сэцэн, Эрдэнийн төвч, Монголын түүхэн сурвалжийн цуврал, VIII боть, хөрвүүлж тайлбарласан М. Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш. Чоймаа, Улаанбаатар, 2006, 146-147 -р тал.

Хос ёсны сургаалын зүйлд багтых их, бага монгол зохиол тун олон байдаг бөгөөд өдгөө хүртэл бүрэн бүртгэж, нэгтгэн судалсан нь үгүй л байна. Монгол, төвд ийм төрлийн зохиолд “ертөнцийн ёс” хэмээхийг янз янзаар нэрийдсэн байдаг. Нэрт эрдэмтэн Алагшаа Агваандандар (1759-1840) бээр хос ёсны сургаалын нэгэн зохиол туурвиж “Хүний номын баяр хурум” хэмээн нэрийдсэн бөгөөд энэ нь Годан ноёны зарлиг болон V Далай ламын “Улаан сувдын эрих” зэрэг зохиолд адиш буй. “Хүний ном” (*শ্রীক্ষ*) хэмээх нь “*ертөнцийн ёс*”, “*ертөнцийн ном*” хэмээсэнтэй утга нэг юм.

Хос ёсны сургаал хэмээхийг өнгөц хуудмаар зөвхөн шашин, төр хоёулыг тэгшид агуулах ёс хэмээн ухаарч үл болно. Энэ сургаал нь хаад, ноёд, түшмэд язгууртад, харц албат, лам хувраг алийн нь ч хэмээсэн бие, хэл, сэтгэлээр үйлдэх аливаа үйлээ буян, нүглийн үр дагавраар шинжилж, сэтгэлээ ариусгахыг насад хичээж, авах гээхийн ухаанаар тунгааж, бас тус тусын язгуурын суртахуунаа сахиж явахыг сургасан явдал мөрийн цогц хөтөлбөр юм.

Хос ёсны сургаалаар явдал мөрөө засаж чадваас хүний сэтгэлийг айх, ичих мэдрэмж жолоодох болно. Айх мэдрэмжтэй хүн хууль цаазыг үл зөрчинө. Ичих мэдрэмжтэй хүн бичигдээгүй хууль болсон хүний ёсыг үл гажуудуулна.

S U M M A R Y

In this article the Doctrine of Two Principles is traced from the time when, according to historical legends, the universe was created and its first king Mahasamadi appeared. Among the Mongolians the Doctrine of Two Principles started to spread out since the time when Sakya pandita Gungaajaltsan (1182-1251) was invited to Mongolia by Godan Khan (1205-1251), who was dedicated to the Buddhist religion. As mentioned in "The Chronicles of the Cakya Genealogy", compiled in 1629 by Agvangungaa Sodnam, Godan Khan ordered that he would support with the state doctrine while Sakya pandita should deal with the religious teachings, then the Shagjamuna's religion would spread throughout the land till the outer ocean. In this saying the Doctrine of Two Principles is clearly meant. During the Yuan Dynasty Khubilai Khan kept the doctrine quite strictly in his state policy. It can be clarified from his edit to the Tibetan monks and the mass, issued in 1264, the period earlier than "White Chronicle" was compiled. This document asserts how Khubilai Khan comprehended the Two Principles.

The content of the "White Chronicle" is reviewed in this article shortly since the chronicle presents the basic legislative document to conduct both the civil and religious affairs to satisfy the mass in joyfulness of body, speech and mind.